

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн  
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн  
12 дугаар тогтоолын хавсралт



БАТЛАВ  
ЭМГЭГ СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ЕРӨНХИЙ  
МЭРГЭЖИЛТЭН  
*Баярмаа*  
Э.БАЯРМАА

### ЛАБОРАТОРИЙН ТЕХНИКЧ / АНАТОМИЙН ЭМГЭГ СУДЛАЛЫН/

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эмгэг гистологийн лабораторид мэргэжлээрээ 8-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;
2. Гистологийн лабораторийн техникч нарын багт ажиллаж, удирдах чадвар эзэмшсэн байх;
3. Эмнэлгийн дунд мэргэжилтний болон бусад эрдэм шинжилгээний бага хуралд 3-аас доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байх / хамтарсан байж болно;
4. Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх /гэрчилгээний хуулбар/;
5. Лабораторийн орчин үеийн автомат технологи, холбогдох программ эзэмшсэн байх;
6. Гистологийн лабораторийн үндэсний болон олон улсын стандартын талаарх мэдлэгтэй байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Ахлах зэрэг хамгаалснаас хойш 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх;
2. Гистологийн лабораторийн шинэ технологи, тэргүүн туршлага эзэмшсэн байх;
3. Өөрийн мэдлэг, дадлага, хандлагаа залуу лабораторийн техникч нарт эзэмшүүлэн шавь төрүүлсэн байх;
4. Ахлах зэрэг хамгаалснаас хойш эмнэлгийн дунд мэргэжилтний болон бусад эрдэм шинжилгээний бага хуралд 5-аас доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байх;
5. Компьютерийн хэрэглээний программуудыг бүрэн ашиглаж зайн сургалт явуулах чадвартай байх;
6. Гистологийн лабораторийн чанарын баталгаа, хяналтыг хийх чадвартай байх.